

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +31
Шөнө +19

УЛС ТӨР
Б.ЧОЙЖИЛСҮРЭН: ГАДААД ЗЭЭЛИЙН ӨГЛӨГ ДОЛООН ИХ НАЯД ТӨГРӨГ БОЛСОН
II нүүрт

ДЭЛХИЙ
ПАК ГЫН ХЕД ЦААЗЫН ЯЛ ОНООНО ХЭМЭЭН СҮРДҮҮЛЭВ
IV нүүрт

Дугаарын **60** мөр
Сэрэмж илүүдэхгүй,
үер уснаас
болгоомжлоорой

ХӨН ЮУ ХӨЛЭВ

Г.ГАНЧИМЭГ

Өнгөрсөн жил бичин жилийн зуд, 1966 оны үер гээд байгалийн гамшигт үзэгдлийн талаар үе үе ярьж битүүхэн болгоомжилж байлаа, хүмүүс. Ашгүй “муу нүүрт” бичин жилийн зуд турхан гайгүй өнгөрч таван хошуу малын маань тоо толгой 60 саяас давсан сайхан мэдээтэй урин цагтай золгосон билээ. Үүнээс өмнө муу амласандаа ч биш сэрэмжилж болгоомжилсондоо л тэр биз “1966 оны үерээс хойш яг 50 жил өнгөрлөө. 50 юу уу 60 жилийн давтамжтай их ус бууж, үер болдог юм гэнэ лээ” гэх мэтээр цуурсан их мэдэгчид бас байсан. Азаар бороо хур ихтэй сайхан зусч, айгаад байсан аюул холуур өнгөрсөн. Харин энэ жил нэг л эвгүй. Байгаль дэлхийн онго хаа сайгүй л гандуу, ган гачиг ихтэй байсаар зуны эхэн сарыг барах нь. Түүх сөхвөл, хуртай жил биш харин гантай жил л их, бага хэмжээгээр үер усны аюул болж байжээ. Тухайлбал, 1966 оны зуны эхэн сард хур бороо багатай байсаар наадмтай золгож.

С.Ганбаатар: СЕХ илбэ үзүүлсэн

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгууль энэ сарын 26-нд болсон билээ. Гэвч гурван нэр дэвшигчээс хэн нь ч сонгуулиа өгсөн сонгогчдын 50-иас дээш хувийн саналыг авч чадсангүй. Ингэснээр хоёр дахь шатны буюу дахин санал хураалт болохоор болсон. Харин эхний шатнаас гурваар гарсан С.Ганбаатар дахин санал хураалтаас хасагдчихаад байгаа. Тэрбээр сонгуулийн асуудлаар хэвлэлд ярилцлага өгчээ. С.Ганбаатар “Энэ сонгуулийн сурталчилгаанд Н.Энхбаяр даргын нөлөө маш их байсан. Тэр хүний туршлага, кампанит ажлын менежмент, шударга үнэний төлөө олон жил өөрсдийгөө золиос болгож ирсэн МАХН-ын мянга мянган хүмүүсийн хөдөлмөр юм. Хамгийн чухал нь Монголын ард түмэн тусгаар тогтнол, язгуур эрх ашиг, мандан бадралын төлөө тууштай зүтгэхээс өөр аргагүй болсон юм байна гэдгийг ойлгосон нь бидний хамгийн том давуу тал байсан. Сонгуулийн өмнөх судалгаагаар би нөгөө хоёр нэр дэвшигчээс аль алинаас нь илүү байсан.

Надтай арай ойролцоо нь Х.Баттулга нэр дэвшигч байсан л даа. Сонгуулийн ерөнхий хороон дээр маш олон амьгүй албатууд буюу үнэмлэх хэвлэсэн гэж үзэж байгаа. Мөн Сонгуулийн ерөнхий хороо илбэ үзүүлсэн. Монголчуудыг унтаад босоод ирэхэд л сонгуулийн дүнг эргүүлдэг. Ямар сайндаа онигоо гарсан байхав дээ. Саяын сонгуулийн санал тооллого нар буцаад хамгийн богино шөнө болсон. Хэрэв жаахан урт шөнө байсан бол Баттулгыг гүйцэх юм билээ гээд гадуур ярьж байна шүү дээ. Ард түмэн ухаантай, мэдэж байгаа. Сонгуулийн ерөнхий хороог татан буулгах ёстой. Энэ удаад МАНАН-гийн дарангуйлал эцэс болж байгааг харуулсан сонгууль болж өнгөрлөө. Мөн 30 мянган хүний саналын зөрүү гарсан. Энэ асуудлыг би шалгуулна. СЕХ, Р.Содхүү даргатай Иргэний бүртгэлийн газар том том луйвар хийж байгаа. Ганбаатар өөрийнхөө төлөө шалгуулах гээд байгаа юм биш. Шударга үнэний төлөө тэмцэгч олон хүний төлөө би шалгуулна. Тэмцэх ёстой. Монголын ард түмний сонголтыг луйвардана гэдэг бол төрийн эсрэг гэмт хэрэг. Энэ байдлыг таслан зогсоох ёстой” хэмээн ярьжээ.



ТЭРҮНОФҮЖИ:
a o ð è é ä ° ° ö ý ð õ î ë
ü à à õ ù ä ò à ò ì à à ò à à à é í à

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

2015 оны тавдугаар сарын 27-ны өдөр Японы мэргэжлийн сүмо бөхийн холбооноос Тэрүнофүжи Г.Ган-Эрдэнэд эзэки /монгол бөхийн арслан цолтой дүйнэ/ цол гардуулсан билээ. Тухайн үед 1989 оноос хойш төрсөн залуу бөхчүүдээс эзэки цол хүртсэн анхны залуу бөх нь Тэрүнофүжи Г.Ган-Эрдэнэ болж байсан гэдэг. Түүнээс хойш олон олон барилдаанаар монголчуудаа баярлуулсаар ирсэн юм. Өнгөрсөн гуравдугаар сарын барилдаанд түүнийг давахад япончууд “Монгол руугаа зайл” хэлсэн хашигч дургүйцлээ илэрхийлсэн нь тухайн үедээ л шуугиан тарьж байсан гэдэг. Харин өнгөрөгч тавдугаар сарын башёг тэрбээр 12 даваа гурван унаатайгаар өндөрлүүлсэн билээ. Ингээд түүний “taishu.jp” сайтад нийлэгдсэн ярилцлагыг орчуулан хүргэе.

Үргэлжлэл нь VII нүүрт

ДЭЛХИЙ
Ши Жинпин Хонконгод анх удаагаа айлчилж байна
Б.СУМБЯА

БНХАУ-ын дарга Ши Жинпин өчигдөр Хонконгод айлчиллаа. Энэ онд Хонконгийг Умард Ирландын нэгдсэн вант улсаас БНХАУ-д шилжүүлсний 20 жилийн ой тохиож буй бөгөөд тус тэмдэглэлт ойн үйл ажиллагаанд оролцохоор Ши Жинпин гэргийн хамт айлчлал хийж байна.

Үргэлжлэл нь IV нүүрт



ХЭРХЭН NONGSHIM
ХОНЖВОРТ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ВЭ?

1 Та өөрт ойр байрлах дэлгүүрээс Nongshim брэндийн том аягатай Э-н төрлийн бүтээгдэхүүн болох Кимчигэй, Мөөгтэй Мөн Хонжын махтай бүтээгдэхүүнээс хуваалдан авалт хийх.

2 Энэхүү Э-н төрлийн бүтээгдэхүүн дотроос хонжвортой карт гарч ирсэн тохиолдолд Та супер хонжворуудын эзэн болох боломжтой.

3 Хэрэв хэрэглэгч та хонжвортой картын эзэн болсон тохиолдолд Грийн Сити компанийн П-457891 үтсанд холбогдож хонжвороо авах боломжтой.

Урамшууллын хугацаа 2017.08.31 ХҮРТЭЛ

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2345.00	2359.00	ФУНТ	2998.00
ЕВРО	2650.00	2701.00	РУБЛЬ	38.80
ИЕН	20.81	21.11	ЮАНЬ	343.00

Хуудалгаа хөгжлийн банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2340.00	2359.00	ФУНТ	3008.00
ЕВРО	2647.00	2717.00	РУБЛЬ	38.61
ИЕН	20.60	21.19	ЮАНЬ	344.00

УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Б.ЧОЙЖИЛСҮРЭН:

Гадаад зээлийн өглөг долоон их наяд төгрөг болсон

Н.БАТЗАЯА

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбогдуулан түр завсарлаад байсан билээ. Тэгвэл өчигдөрөөс Төрийн ордон хаалгаа нээж, гишүүд ажилдаа орлоо. Тодруулбал, өчигдөр 11:00 цагт байнгын хороод, 15:00 цагт УИХ-ын нэгдсэн чуулган хуралдлаа. Хэсэг хугацаанд амралтаа авсан гишүүд ажилдаа хэрхэн ирцтэй ирснийг хүргэе. Энэ удаагийн нэгдсэн чуулганы хуралдаанд төвлөсөн цагтаа ирсэн гишүүд байсангүй. Ихэнх нь таван минутаас нэг цаг хүртэлх хугацаанд хоцорч ирэв. Харин Ж.Батзандаан, О.Содбилэг, Г.Солтан, Ч.Улаан, Д.Ганболд, Б.Наранхүү, Н.Номтойбаяр, С.Эрдэнэ нарын гишүүд тасалсан бол Ш.Раднаасэд, С.Жавхлан, Х.Нямбаатар нарын гишүүд чөлөө авчээ. Байнгын хороод болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцсэн олны анхаарал татсан асуудлыг тоймлон хүргэе.



Тэрхүү зурвас 1. АРГУУЖИН

Б.Пүрэвдорж: Тэтгэврийн насыг 65 болгон нэмэхийг АН эрс эсэргүүцэж байна

Байнгын хорооны хуралдаанаар олон нийтийн анхаарал татсан хэд хэдэн асуудлыг хэлэлцсэн нь энэ сарын 23-нд Засгийн газрын өргөн мэдүүлсэн Нийгмийн

даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл байлаа. УИХ-ын хаврын чуулганаар ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөрт хамрагдахын тулд төсвийн тодотголыг яаралтай батлах тухай асуудал үүсч, төсвийн тодотголд хэд хэдэн асуудлыг тусгасан билээ. Түүний нэг нь тэтгэврийн насыг нэмэх асуудал байсан юм. Өөрөөр хэлбэл, өнөөгийн тэтгэврийн тогтолцоонд шимтгэлийн хэмжээ, тэтгэврийн хэмжээ ба тэтгэврийн насны зохистой тэнцвэр хангагдаагүй байгааг сайжруулах зорилгоор тэтгэврийн насыг хүн амын насжилттай уялдуулан аажмаар нэмэгдүүлж, эрэгтэйчүүдийн тэтгэврийн насыг 2027 онд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг 2037 онд 65-д хүргэхээр тусгасан. Гэвч уг шийдвэрийг УИХ дахь Ардчилсан намын гишүүд эрс эсэргүүцэж байсан юм. Үүний үр дүнд Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцлээ. Энэ үеэр АН-ын гишүүн Б.Пүрэвдорж “Өнгөрсөн хаврын төсвийн тодотголоор тэтгэврийн насыг 65-д хүргэсэн. Тэтгэврийн насыг нэмж байгаа шалтгаанаа хүргэж байгаа гэж тайлбарласан. Дэлхийн жишигт цөөхөн орон 65 насаар тогтоосон байдаг. Гэхдээ ихэнх нь Европын орнууд бий. Тэд бол иргэдийнхээ нийгэм эдийн засгийн асуудлыг бүрэн шийдвэрлэдэг орнууд. Иргэд нь өндөр насладаг. Тэд тэтгэврийн

мөнгөнд ойролцоогоор 2000 орчим евро өгч байгаа. Гэтэл манай улсын иргэдийн тэтгэврийн мөнгө дунджаар 300 мянган төгрөг байна. Тэтгэврийнх нь мөнгийг дэлхийн жишигт хүргээгүй байж, насыг нь дэлхийн жишигт хүргэх гэсэн нь буруу шийдвэр болохыг харуулсан. Олон ахмадууд 40 гаруй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлчихөөд дөрөвхөн жил түүнийгээ авах ийм л нөхцөл байдалд хүрлээ. Яагаад дөрвөн жил гэж хэлсэн гэвэл, Манай улсын иргэдийн дундаж наслалт 69.5. Олон хүн 65 нас хүрэлгүй хорвоог орхиж байна. Тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төлчихөөд тэтгэврээ авч чадалгүй өнгөрсөн олон тохиолдол бий. Ер нь хөдөө орон нутгийн иргэдтэй уулзалт хийгээд явахад хүмүүс дургүйцэж байна билээ. Зарим залуус босч ирээд үг хэлж байна лээ. Б.Пүрэвдорж гишүүн энэ би нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй. Яагаад гэвэл би 65 нас хүрэхгүй ч байж мэднэ. Түүний оронд Улаанбаатар хотод ипотекийн эзэлээр орон сууц аваад өнөөдрийн ханшаар 800 мянган төгрөгөөр түрээсэлвэл тэтгэврийн 300 мянгаас илүү мөнгө авна гэж хэлсэн. Тиймээс 65 нас хүргэх гэдэг шийдвэр тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхад хүргэж байна. Энэ шийдвэр эргээд нийгмийн даатгалын санг дампууруулах хариуцлагагүй шийдвэр болсон. МАН-ын гишүүд сонгуулийн үеэр иргэдтэйгээ уулзаж явлаа. Нэлээд эсэргүүцэлтэй тулгарсан болов уу. Тиймээс сонголтын асуудлыг оруулж ирж байх шиг байна. Энэ сонголтоор зогсч болохгүй. Тиймээс 60 настай тэтгэвэрт гарах талаар АН-ын

бүлэг хатуу байр суурьтай байна гэдгийг хэллээ” гэв. Мөн 2016 оны арванхоёрдугаар сарын 28-нд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн юм.

Гадаад зээл долоон их наядад хүрсэн гэв

УИХ-ын нэгдсэн чуулганы эхэнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” төслийг хэлэлцлээ. Уг төслийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн УИХ-ын гишүүдэд танилцуулсан юм. Тэрбээр “2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн тайланг олон улсын стандартад заасны дагуу бүтэц бүрэлдэхүүнээр тайлагнасан болно. Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд улсын болон орон нутгийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан төрийн болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл санхүүгийн тайланг нэгтгэлээ. Засгийн газрын нэгтгэсэн тайланд нийт 31.2 их наяд төгрөгийн хөрөнгө, 24.8 их наяд төгрөгийн өр төлбөр, түүнээс мөнгөн хөрөнгө 2.9 их наяд, авлага 4.6 их наяд, урт

хугацаат хөрөнгө оруулалт 5.6 их наяд, үндсэн хөрөнгө 13.3 их наяд төгрөг тайлагнагдсан байна. Нийт өр төлбөрийн дүнд төрийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжүүдийн өр төлбөр 7.6 их наяд, Засгийн газрын хүлээх дотоод үнэт цаасны өглөг дөрвөн их наяд, гадаад үнэт цаасны өглөг 5.4 их наяд, гадаад зээл долоон их наяд төгрөг байна” гэв. Энэ үеэр гишүүд дараах асуудлыг асууж, хариулт авлаа.

З.Нарантуяа: Орлого, зарлагын мэдээлэл үнэн бодит уу

Үндэсний аудитын газрыг Монгол Улсын Засгийн газрын төсөв, санхүүгийн гүйцэтгэлд бодитойгоор бие даасан байгууллагын хувьд ажиллах байх гэж найдаж байна. Ялангуяа УИХ-ын Зарлагын хяналтын хороонд хоёр дахь шатны хэлэлцүүлгийн үеэр энэ асуудал яригдах ёстой. Хоёр зүйлд юу гэж бодсон бэ гэдгийг асууя. Нэгдүгээрт, орлого, зарлагын нэг нь давсан, нэг буурсан тоонууд хэр бодитой байна вэ. Би үүнийг үнэхээр орлогоогынхоо төрлийг нэмээд орлого олчихлоо, илүү давуулчихлаа, хэмээлт гаргаад зарах ёстойгоосоо дутуу зарчихлаа гэж хархгүй байгаа. Яагаад гэвэл 2016 оны төсвийн тодотголоос харвал бид орлогоо нэг их наяд 584 тэрбум төгрөгөөр хасч тодотгосон. Үүний нэг их наядыг татварын орлогоо авч чадахгүй гэх шалтгаанаар бууруулсан. 578 тэрбум төгрөгийг татварын бус орлого, боломжгүй орлого гээд бууруулсан шүү дээ. Одоо болохоор 405 тэрбумаар

давуулчихлаа гэж ярьж байна. Та нар Зарлагын хяналтын хороонд орж ирэхдээ ийм задаргаа гаргаач гэж хүсч байна. Бидний бууруулж тодотгосон 1.5 их наяд чинь аль аль руу нь орсон юм бэ. Авч чадахгүй гэсэн зүйлүүд яагаад эргээд ороод ирсэн байна. Яаж авч чадсан юм бэ гэдгийг харуулах хэрэгтэй байна. Түүний дараа бид үнэхээр бодит орлого уу, цаасан дээр тоо тавиад нэгнийгээ хуурах гэсэн оролдлого уу гэдгийг харж чадна. Хоёрдугаарт, олон зөрчлийн талаар ярьж байна. Үүнд тайлбар хийхдээ ихэвчлэн өмнөх Засгийн газрын үед гарсан гэлээ. Хамтарсан Засгийн газар болон хамтраагүй Засгийн газрын алдааг ялгаад гаргаад ирээч.

Х.Баделхан: Төрийн өмчит компаниудын өр Монгол Улсын жилийн орлоготой тэнцэж байсан

Өнгөрсөн онд Засгийн газар солигдох үед төрийн өмчийн компаниуд маш их өртэй гарсан. Зургаан их наяд буюу Монгол Улсын жилийн орлоготой тэмцэх хэмжээний өртэй байсан. Өрийг байгуулах талаар Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг гарч ажилласан. УИХ-ын тогтоолоор заалт өгсөн юм. Өнөөдрийн байдлаар уг ажлын хэрэгжилт ямар байна вэ. Төрийн өмчит компаниудын өрийн төвшин хэр буурсан бэ. Өнөөдрийн өрийн төвшин ямар хэмжээнд байна вэ.

ҮАГ: “Шивээ овоо” компани худалдан авсан 0.4 тэрбум төгрөгийн материалаа данс бүртгэлд тусгаагүй

Төрийн өмчит хуулийн этгээдийн бараа материалын үлдэгдэл 599.9 тэрбум төгрөг байснаас 304.3 тэрбум төгрөгөөр оны сүүлийн хагаст буурууллаа. 295.6 тэрбум төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй аудитын тайлангаар тайлагнагдсан. Энэ нь “Эрдэнэс тавантолгой” төрийн өмчит компани бараа материалын дансанд бүртгэлтэй 2.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 26 ширхэг дутуйг үйлдвэрлэлд ашиглах боломжгүй болсон. “Шивээ овоо” төрийн өмчит компани худалдан авсан 0.4 тэрбум төгрөгийн бараа, материалыг данс бүртгэлд тусгаагүй гэсэн зөрчлүүдэд аудитын тайланг хязгаарлаж, хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн саналын хуудсыг нисдэг төргээр хүргэнэ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль энэ сарын 26-нд явагдсан ч гурван нэр дэвшигчийн хэн нь ч 50 хувиас дээш санал аваагүй тул дахин санал хураалт явуулахаар болсон билээ. Үүнтэй холбогдуулан СЕХ-ноос хоёр дахь шатны сонгуулийн долдугаар сарын 7-нд явуулах тухай шийдвэрийг гаргасан юм. Харин гадаадад байгаа иргэдийн саналыг ирэх сарын 4-5-нд зохино байгуулахаар болсон. Дахин сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд СЕХ-оос

санал хураалтад шаардлагатай техник хэрэгсэл, саналын хуудсыг богино хугацаанд найдвартай хүргэх ажлыг судалж эхэлжээ. СЕХ-ноос аймаг, сумдад нисдэг төргээр саналын хуудсыг түгээх боломжийг судалж байгаа гэнэ. Тэд Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штаб, Иргэний нисэх, аэрo компанийнхантай уулзахад зарим нислэгээ зохицуулж, техник хэрэгсэл, саналын хуудас хүргэлтэд дэмжлэг үзүүлэхээр болсон байна.

Шилжилт хөдөлгөөнийг түр хязгаарлалаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтыг долоодугаар сарын 07-ны болгон зарласан билээ. Тэгвэл уг шийдвэртэй холбогдуулан Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэдийг засаг захиргааны нэг нэгжээс өөр нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг зургадугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас долдугаар сарын 10-ны

өдрийн 08:00 цаг хүртэл улсын хэмжээнд түр хугацаагаар зогсоохоор болжээ. Энэ хугацаанаас өмнө бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн онлайн системд тусгах, бүртгэлийг баталгаажуулж дуусахыг нийт сум, хорооны улсын бүртгэгч, аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний ахлах бүртгэгч нарт үүрэг болгосон гэнэ.

Комиссын гишүүн П.Оюунчимэг Катарын Аль-Жазира мэдээллийн агентлагт ярилцлага өгөв

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг Ойрхи Дорнодын хамгийн том мэдээллийн агентлаг болох Аль-Жазирад 2017 оны зургадугаар сарын 29-нд хүүхдийн эрхийн асуудлаар ярилцлага өглөө. Аль-Жазира мэдээллийн агентлагийн сурвалжлагч Дрю Амброуз Монголын үндэсний өв соёл хурдан морин уралдааныг сурвалжлагаар ирээд байгаа бөгөөд хурдан морь унаач хүүхдийн эрхийн нөхцөл байдал, хурдан морь унаач хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин болон тус байгууллагаас хийж байгаа ажлуудын талаар мэдээлэл авсан байна. Аль-Жазира мэдээллийн агентлаг Монгол улсад тусгай нэвтрүүлэг бэлтгэхээр ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаандаа

хурдан морин уяачид болон хурдан морь унаач хүүхдүүдтэй уулзаж, наадмын өмнөх сунгааны явцтай танилцан зураг авалтуудаа хийсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах чиглэлээр хангалттай хэмжээнд ажиллаж байгаа эсэхийг Комиссын гишүүнээс тодрууллаа.

“Утааг хамтдаа устгая” чуулган болно




“Утааг хамтдаа устгая” чуулган өнөөдөр болно. Уг чуулга уулзалтад БОАЖЯ, Ариг банк, Эрчим хүчний яам зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцож, “Агаарын бохирдлыг бууруулах технологийг”, “Агаарын бохирдлыг санхүүжилтийн нөлөө” гэсэн хоёр үндсэн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийх гэнэ. Тус чуулган төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, олон улсын байгууллагууд болон судлаачдын

туршлага, мэдлэгт тулгуурлан агаарын бохирдлыг бууруулах, устгах арга технологийг тодруулахад зорилготой аж. Тэгвэл уг асуудлаар өчигдөр БОАЖЯ-нд хэвлэлийн бага хурал хийлээ. Хурлын үеэр Уг асуудлаар БОАЖЯ-ны Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ц.Уранчимэг “Аливаа улс орон ирээдүйнхээ хөгжлийг нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй зарцуулалт, байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоход чиглүүлэх болсныг бид бүхэн мэдэх билээ” гэв.

ҮЗЭЛ БОЛОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ч.Содномцэрэн: Дахин санал хураалтад идэвхтэй оролцоорой

СЕХ хоёр өдрийн өмнө хуралдаж, дахин санал хураалтын товыг наашлуулсан билээ. Тодруулбал, долдугаар сарын 7-ны өдөр Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтыг явуулахаар товчлосон юм. Тэгвэл энэ талаар болон бусад асуудлаар СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн байр сууриа илэрхийлсэн билээ. Тэрбээр “Сонгогчийн ирдэгтэй холбоотой харилцан адилгүй ойлголт байгаад байна. Ирц 50-наас дээш нэмэх нэг сонгогч, санал 50-наас дээш нэг санал байна. Хоёр дахь шатны санал хураалт мөн ирц, саналын босготой. Ирц 50 хувьдаа хүрсэн тохиолдолд тухайн дэвшигч 50 хувьдаа хүртэл санал авсан эсэхийг харна. Ирц хүрсэн эсэхийг үзээд 50 хувийн ирц бүрдээгүй тохиолдолд тухайн хэсэгт санал өгөөгүй иргэдийн дунд нэмэлт санал хураалт явуулах юм. Гадаадад амьдарч байгаа иргэд долдугаар сарын 4, 5-ны өдөр саналаа өгнө. Энэ хугацаанд амжиж, саналын хуудсаа аваачихыг ГХЯ-ны Төв комисст даалгасан. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 68 хувь байсан. Өмнөх жилүүдэд ирц өссөн үзүүлэлт юм. Тиймээс иргэд энэ ирцээрээ дахин санал хураалтад оролцон гэж найдаж байна. Сонгогчид хандсан урамшууллын, торгуулийн арга хэмжээ авахыг Монгол Улсын хуульд зөвшөөрдөггүй. Тиймээс хэвлэл мэдээллийнхэнтэйгээ хамтран сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж байна. Санал авах өдөр аймаг сумдуудад наадам хийхгүй байхыг анхааруулсан. Засгийн газрын хуралдаанаар аймаг сумдад наадам хийхгүй байх шийдвэр гаргасан.

Ж.Хайдав: Аварга С.Мөнхбат, Ч.Санжаадамба, харцага Ц.Содномдорж нар онцгойрч магадгүй

Монгол түмний их баяр наадам удахгүй болох гэж байгаа. Наадмын өмнө алдар цуутай бөхчүүд хэвлэлд ярилцлага, өөр өөрийн таамгаа дэвшүүлж, хүчтэнүүдийн өнгийг ярьдаг. Тэгвэл Улсын арслан Ж.Хайдав

өөрийн таамгаа дэвшүүлж, ярилцлага өгчээ. Тэрбээр “Сүүлийн үед тэр энэ гэж хэлэх аргагүй болсон. Залуучууд сайн бэлтгэл хийж техникжчихсэн. Гэхдээ улсын аварга С.Мөнхбат, Г.Эрхэмбаяр, Ч.Санжаадамба, улсын харцага Ц.Содномдорж нарыг нэрлэж байна. Тэд тун онцгой байж болзошгүй. Тэднийг нэрлэхээр хэн нь түрүүлэх вэ гэдэг асуудал бас гарна. Тэгэхээр тааж болдоггүй юм энэ болоод байгаа. Дээхнэ дархан аварга Ж.Мөнхбат, Х.Баянмөнх нарыг ид байхад энэ хоёрыг л нэрлэдэг байлаа. Дараа нь дархан аварга Б.Бат-Эрдэнэ, улсын арслан Д.Мөнх-Эрдэнэ нар яригддаг болсон. Тэд бусдаасаа үнэхээр тасархай явсан юм чинь аргагүй л дээ. Тэгээд ч тухайн үед бөхийн бэлтгэл сургуулилт тэр бүр тууштай хийгдэж байгаагүй. Морь уургалах, уулнаас мод бэлтгэх, буулгах, ачаа хөсөг татах зэрэг бидний гол бэлтгэл болдог байлаа. Гэтэл өнөөдөр энд тэндгүй бөхийн клуб, дэвжээ байгуулагдсан байхад хэн сайн хөдөлмөрлөсөн нь дээшээ гарч барилдана. Мөн багаас нь тэмцээнд оролцуулахаар жигд хөгжихөөс аргагүй л дээ. Бидний үед хоёр “Мөнх” бараг 20 жил улсын наадам болон бусад барилдаанд ээлжлээд түрүүлчихдэг байв. Тэгэхээр биднээс дээш гарч барилдах хүн ховор байсан. Намайг 1963 онд ХААНС-д элссэний намар үндэсний бөхийн сургуулийн аварга шалгаруулах барилдаан болсон юм. Би нэг их тоогоогүй хэрнээ барилдах гээд бүртгүүлчихлээ. Манай сургуулийн 644 бөх барилдсан. Тэдний дунд дүүгүүр Д.Гомбо-сүрэн, Ч.Бат-Очир нар байв. Эхлээд оноолтоор барилдуулж байгаад сүүлийн найман бөхийн тойргоор барилдуулчихсан. Би анх шахуу барилдаж байгаа болохоор өөртэйгээ таарсаных даваад байна гэж бодсон чинь түрүүлчихдэг байгаа. Тэрнээс хойш жаахан урамшсан.

Ж.Эрдэнэжамьян: МАН ганц хоёр тойргийг барьж байгаад, түүндээ зөрүү саналаа шингээсэн

Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор МАХН-аас маш олон хүн байр сууриа илэрхийлж байгаа. Тэгвэл МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэжамьян ч гэсэн сонгууль булхайтай боллоо хэмээн мэдэгдэж, хэвлэлд ярилцлага өгсөн билээ. Тэрбээр “Ер нь УИХ-ын болоод

Ерөнхийлөгчийн сонгууль болгоны дараа булхай луйвар болсон нь тодорхой болдог шүү дээ. Энэ удаад ч ялгаагүй. Гагцхүү МАН-ын хийсэн луйвар бүх хүний нүдэн дээр улаан цайм ил харагдсанд хэргийн учир оршино. Эл хууль бус үйлдлийг нь ард түмэн ойлгосон байх гэж бодож байна. 2012 оны УИХ-ын сонгуулиар С.Удвал сайд дээр яг ийм зүйл болсон юм. Аймгийн төв дээр нэгээр гараад ирсэн байсан. Дүн гарч, олонхийн санал авсан нь тодорхой болоод ирсэн чинь хэдэн сумын саналын дүн ирэхээ больсон. Гэтэл Засаг дарга нь саналын хайрцага аваад зүтгсэн, хар машинаа аваад зүтгсэн, цахилгаанаа тасалсан хэрэг гарсан. Иймэрхүү арга залиар тэд ялсан байхгүй юу. Шүүхэд явахар ялдаг л юм билээ. Яг үүнтэй адилхан. Монголын 21 аймагт сонгуулийн дүн гарчихаад байдаг. Баян-Өлгийн 20 хэсгийн хорооны үр дүн гардаггүй. Ховдын Үеч сум бас таг. Удалгүй санал унших систем гацаад эхэлсэн. Үүндээ бусад аймгийнх гацсан үед ч ирсээр байсан мөртлөө Баян-Өлгийнх огт ирэхээ больчихож байгаа

байхгүй юу. Тэгээд би бүх хүмүүстэй хэлсэн. Маш хурдан, яаралтай гар талоноо ав гэж. Харамсалтай нь тэд нар талонг нь өгөөгүй. Тодруулж хэлбэл, 22:00 цагт бүх санал авах байрууд үйл ажиллагаагаа зогсоогоод хар машинаас талон авах ёстой юм. Өнөөдрийг хүртэл нэлээн олон газар машин гацсан гээд талоноо өгөхгүй байгаа. Тэгэхээр иймэрхүү зүйл нь өөрөө дээрээс зохион байгуулалттай гэдгийг илчлээд байгаа хэрэг. Магадгүй их мөнгө тараасан, эрх мэдлээр далайгасан сонгууль болж байгаа нь эхнээсээ тодорхой болж эхэлсэн учраас сонгуулийн үр дүнг харж байх гэсэн байдлаар асуудалд хандсан. Хоёр нам ч ялгаагүй. Гэтэл дүн нь өөрчлөгдөөд ирсэн сүүлийн мөчид МАН ганц хоёр тойргийг барьж байгаад түүндээ зөрүү саналаа шингээсэн. Энэ бол Монгол Улсад хэрэгжиж чаддаг сонгуулийн бохир технологийн нэг л дээ. Харамсалтай нь үүнийг хэн хийдэг вэ гэхээр намууд биш, төрийн алба, сонгуулийн хороо нь хийдэг юм. Өөр боломж байхгүй. Тэр хар машин, програмдаа ч байгаа юм биш. Угаасаа сонгуулийг зохион байгуулж байгаа сонгуулийн хэсэг, тойргийн хорооны хүмүүс л хийж байгаа. Харамсалтай байгаа биз. Монголын төрийн албан хаагчид төрийнхөө сонгуулийн будлиулчихаад юу ч болоогүй юм шиг байгаа нь. Ийм л нөхцөл байдал үүсчихээд байна.

Дугаарын **60** мөр

Сэрэмж илүүдэхгүй, үер уснаас болгоомжлоорой

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ингээд долдугаар сарын эхнээс бороошиж эхэлсэн байна. Харин яг наадмаар буюу 10-наас эхэлсэн бороо бүтэн гурван өдрийн турш оржээ. Тэр үеийн хүмүүс “Их эвгүй бөөн хар үүл гарч ирээд л ойролцоогоор 15 минутын дотор хувингаар асгаж байгаа юм шиг их ус цутгачихсан. Улсын баяр наадам эхэлж байсан учраас зон олны сэтгэл хөөрүү. Ер үер усны гамшиг энэ тэр аюулын тухайд тархи толгойд орж ирээгүй. Наадмын эхний өдөр ингэс тэгэс хийгээд өнгөрсөн. 11-ний өглөө ч талбай дээр жагсаалаа хийсэн юм даг. Бороо тасралтгүй ороод л байсан. Цэргийн жагсаал шагайгаа давсан усыг туучаад л өнгөрсөн. Дараа нь биеийн тамирын жагсаал бодогоороо л болов. Хүүхэд залуучууд ер тоосон шинж байгаагүй. Харин ч бороо ороод аятайхан санагдаж байлаа. Тэгээд араас нь хөдөлмөрчдийн жагсаал явж, албан ёсоор наадмын нээлтээ хийсэн. Бороо өдөржингөө орсоор л байлаа. Орой нь Их Тэнгэрийн аманд Засгийн газрын наадмын хүлээн авалт ч боллоо. Хүлээн авалт тарах үеэр нөхцөл байдал эвгүй болсон. Тэнгэрийн дуу гэж аймшигтай. Амьдралдаа анх удаа тийм аймаар дуу шуугиан сонссон” гэж дурсцаасаа нь бий.

Энэ жил ч яг тэр үеийнх шиг дүр зураг харагдаад байна. Хур бороогүй, гандуу, хуурай зун болж байна. Гол ус бараадсан хүмүүс Туулын эргээр шаваастай. Харин онцгой байдал, цаг уурын албаны хүмүүс “Үер усны аюулаас сэрэмжилж болгоомжлоорой” гэдгийг үе үе сануулсаар буй.

Харин хашир туршлагатай аврагчид “Үерийн гамшигт урьдчилсан бэлтгэлтэй байна уу гэхээс нүүр тулсан хойно нь хамгаална гэж байхгүй” гэдгийг хэлж байна. Ямар ч гамшиг, тэр дундаа байгалийн аюулт үзэгдэл урьдчилан сануулж, хэлж ирэхгүй. Тиймээс л урьдчилсан бэлтгэлтэй байх ёстой аж. Наад зах нь зун цагт гуу жалга, үерийн аман дээр буухгүй. Үерийн далан руу хог новшоо асгаж бөглөхгүй байх, эргэж тойрч, бөглөрсөн

бол хог новшийг нь гаргаж цэвэрлэх зэрэг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх хэрэгтэй зөв дадал манай иргэдэд учир дутагдалтай. Харин ч дээрээс нь нэмээд хог новшоо чихээд байдаг буруу зуршилтай аж. Тиймээс одоо үерийн далангийн бүрэн бүтэн байдлыг холбогдох газрууд нь шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээг оройтоогүй дээрээ хийж, ойр орчимд нь амьдарч буй иргэд нийлээд хог новшийг нь цэвэрлэж яагаад болохгүй гэж. Энэ чинь эргээд амь нас, эд хөрөнгөө болзошгүй эрсдэлээс хамгаалж буй нэг хэлбэр юм. Харин зарим аврагч “Их бороонд хүн нүцгэн байж болохгүй. Өөрөөр хэлбэл, тэртэй тэртэй норчихсон юм чинь гэдэг байдлаар хувцсаа тайлж бүр болохгүй. Хувцас шалба норлоо ч дотор талд нь биеийн халуунд хүн осгодоггүй. Осгох, хөлдөх хоёр чинь огт өөр ойлголт. Тиймээс ямар ч их бороо орж байсан хүн нүцгэн байж болохгүй. Өөрөөр хэлбэл, тэртэй тэртэй норчихсон юм чинь гэдэг байдлаар хувцсаа тайлж болохгүй” гэж зөвлөв. Мөн яалт ч үгүй их усанд хөл алдаад эхэлбэл шумбаад сэлэх хэрэгтэй гэнэ.

Харин үүнийг биелүүлэхэд олон хүнд эцүү, бараг биелэх боломжгүй санагдаж байгаа болов уу. Социализмын үед манай улсад “Иргэний хамгаалалт” гэдэг хичээл ордог байлаа. Харин одоо үүнийг сэргээж, орчин дурсцаасаа нь бий.

Энэ жил ч яг тэр үеийнх шиг дүр зураг харагдаад байна. Хур бороогүй, гандуу, хуурай зун болж байна. Гол ус бараадсан хүмүүс Туулын эргээр шаваастай. Харин онцгой байдал, цаг уурын албаны хүмүүс “Үер усны аюулаас сэрэмжилж болгоомжлоорой” гэдгийг үе үе сануулсаар буй.

Харин хашир туршлагатай аврагчид “Үерийн гамшигт урьдчилсан бэлтгэлтэй байна уу гэхээс нүүр тулсан хойно нь хамгаална гэж байхгүй” гэдгийг хэлж байна. Ямар ч гамшиг, тэр дундаа байгалийн аюулт үзэгдэл урьдчилан сануулж, хэлж ирэхгүй. Тиймээс л урьдчилсан бэлтгэлтэй байх ёстой аж. Наад зах нь зун цагт гуу жалга, үерийн аман дээр буухгүй. Үерийн далан руу хог новшоо асгаж бөглөхгүй байх, эргэж тойрч, бөглөрсөн

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **19800**

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ДЭЛХИЙ

Израилын экс сайд Эхуд Олмертыг суллана

Авлигын хэргээр шүүхээс ял сонссон Израилын экс Ерөнхий сайд Эхуд Олмертод холбогдох хэргийг тус улсын Батлан даалтын хороо хэлэлцэж үзээд хугацаанаас нь өмнө суллах шийдвэр гаргажээ. Энэ талаар өчигдөр түүний өмгөөлөгч нь олон нийтэд мэдээллээ. АНУ-ын нэр бүхий бизнесмэнээс дугуйтай мөнгө авсан гэх хэргээр экс сайд чанга дэглэмтэй хорих ангид 27 сарыг өнгөрүүлэх ял сонссон юм. Тэгвэл өчигдөр түүний өмгөөлөгч нь орон нутгийн радиод ярилцлага өгөхдөө “Батлан даалтын хороо бидний хүсэлтийг хүлээн авч хэлэлцсэн. Энэ дагуу Эхуд Олмертыг ирэх долодугаар сард суллахаар болсон” гэж ярьжээ.

Нөгөөтэйгүүр, тус улсын Хууль зүйн яам энэ удаагийн шийдвэрийг үл зөвшөөрсөн тохиолдолд давж заалдах боломжтойг онцолсон байна. 2006 оноос 2009 он хүртэл Ерөнхий сайдаар ажиллаж байсан Э.Олмерт 2012 онд тус хэрэгтэй холбоотойгоор шүүгдэж, 19 мянган ам.долларын торгууль, тэнсэн харгалзах ял сонсч байжээ. Мөн хууль бус үйл ажиллагаа, авлигын хэргийг нь хэрэгсэхгүй болгож байсан аж. Гэвч экс Ерөнхий сайдын өөр бусад авлигын хэргүүд шинэ шинэ нотлох баримттайгаар олон нийтэд дэлгэгдсэнээр прокурорын байгууллага дахин шүүхээр хэргийг хэлэлцэх хүсэлт гаргаж, 27 сарын ял ногдуулаад байсан юм.



ХОНКОНГОД АНХ УДААГАА АЙЛЧИЛЖ БАЙНА

Үргэлжлэл.
Түүрүү нь I нүүрт

БНХАУ-ын төрийн тэргүүний тухайд өнөөгийн албан тушаалдаа томилогдсоноос хойш анх удаагаа Хонконгод айлчилж буй нь энэ юм. Ши Жинпин, түүний гэргий Пэн Лиюан нар “Эйр Чайна” онгоцоор Хонконгийн олон улсын нисэх онгоцны буудалд очигдөр газардсан бөгөөд түүнийг хөгжимчид болон тавтай морилон саатгахыг хүсэн ерөөсөн үгнүүдийг бичсэн лоозон, БНХАУ-ын далбааг барьсан хүүхэд багачууд угтан авсан байна. Үүний дараа Ши Жинпин нисэх онгоцны буудалд богно хэмжээний мэдэгдэл хийгээд амжжээ. Тэрбээр “Есөн жилийн дараа Хонконгийн эх газарт саатаж байна. Сэтгэл үнэхээр өндөр байна. Миний зүрх сэтгэлд үргэлж Хонконг байсаар ирсэн” гэжээ. Түүнчлэн, БНХАУ-ын Засгийн газар цаашдаа ч Хонконгод тусалж дэмжиж байгаа илэрхийлсэн аж.

Ши Жинпин Хонконгод гурван өдрийн хугацаатай айлчлал хийхээр төлөвлөсөн бөгөөд маргааш нутаг буцах юм. Хонконг нь Хятадын өмнөд хэсэгт оршдог билээ. Тус улс

1942 оноос 1997 онд Хятадад шилжүүлэгдэх хүртлээ Их Британийн засаг захиргаанд байжээ. Хятад-Британийн хамтарсан тунхаг болон Хонконгийн Үндсэн хуульд зааснаар шилжүүлгээс тавин жилийн дараа буюу доод тал нь 2047 он

хүртэл Хонконг нь Хятадаас автономит байдалтай байх ёстой юм. Энэ оны тухайд БНХАУ-ын тусгай засаг захиргааны нэгж болсноос хойш 20 жилийн ойгоо угтаж буй Хонконг тусгаар тогтносон улс болоход дахиад 30 жил үлдлээ. Ши Жинпин 20 жилийн ойн үйл ажиллагаанд оролдох сургаар Хонконгийн ардчиллын төлөөх “шүхэрт хувьсгалчид” ч зүгээр суусангүй. Хятадын харьяанд эргэн ирснийг тохиолдуулан Бээжингийн зүгээс Хонконгт бэлэглэсэн хөшөөний өмнө 2014 онд ардчилсан сонгууль хийхийг шаардан эсэргүүцлийн жагсаал хийж байсан оюутан болон Хятадын Засгийн газрын эсэргүүцдэг улс төрийн намын гишүүд нийлсэн 20 орчим хүн мягмар гарагийн орой суулт хийжээ. Тэд ардчиллыг

дэмжихийг шаардахаас гадна, нобелийн энх тайвны шагналт зохиолч Лю Сяобог ямар нэгэн болзолгүйгээр суллахыг Бээжингийн эрх баригчдаас шаардсан байна. Элэгний хорт хавдартай гэж оношлогдсон Нобелийн шагналтныг саяхан батлан даалтаар түр суллаад байгаа юм. Цагдаа нар эсэргүүцдэг илэрхийлэгчдэд хэдэн цагийн турш хяналт тавьж, хөшөө рүү авирсан хүмүүсийг баривчилсан байна.

БНХАУ-ын төрийн тэргүүнүүд дундаас 2012 онд Ху Жинтао тус улсад айлчилж байжээ. Тухайн үед Хонконг Хятадын харьяанд дахин ирсний 15 жилийн ой төлөө байсан бөгөөд хэдэн зуун мянган иргэд эсэргүүцлийн жагсаал хийж, улс төрийн шинэчлэлтийг шаардаж байсан байна.

Ромын папын нярав ял сонсч магадгүй

Ватиканы нярав Кардинал Жорж Пеллыг төрсөн нутаг Австралийнх нь хуулийн байгууллагынхан бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт буруутгажээ. Гэвч, тэрбээр өөрт холбогдох хэргийг ямар ч үндэслэлгүй хэмээн няцааж байгаа аж.

Италийн Ром хотод амьдарч буй Ж.Пелл ирэх сарын 18-нд Мельбурн хотод болох шүүх хуралд оролцох ёстой юм. Гэвч тэрбээр өөрийг нь буруутгаж буй үндэслэлийг эрс няцаагаад “ариун нэр төрөө хамгаална” гэж мэдэгджээ. Хүүхдүүдийг хүчирхийлсэн хэргүүд болон ниймэрхүү хэргүүдийг нуун далдлахад католик сүмүүдийн оролцоо ямар байсан гэдгийг мөрдөн шалгах тусгай комисс Австралид байгуулагдсан байна. Комисс байгуулагдах болсон шалтгаан нь хүүхдүүдийг садар


самуунд уруу татсан хэргээр ял эдэлсэн Жеральд Рисдейл гэгч санваартантай холбоотой ажээ. Тэрбээр 1960-1980-аад оны хугацаанд нийгдээ 130 эрэгтэй хүүхдийг хүчирхийлсэн хэргээр ял сонссон байна.

Харин Ж.Пелл 1970-аад оны эхээр Рисдейлтэй хамт нэг байшинд амьдарч байсан учраас түүний үйлдсэн хэргүүдийн талаар болон бусад санваартнуудын хийсэн зүй бус үйлдлийн талаар ч мэдэж байх ёстой гэж тусгай комисс үзжээ. Ингээд Ж.Пелл энэ оны хоёрдугаар сард тус комисст мэдүүлэг өгсөн байна. Энэ оны эхээр Австралийн католик сүмийн төлөөлөгчдийн мэдэгдсэнээр, санваартнуудын үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд 213 сая долларын нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн аж.

Д.Трампа дараагийн сонгуульд хэрэглэх мөнгөө хуримтлуулсад эхэлжээ

АНУ-ын ээлжит Ерөнхийлөгчийн сонгууль болоход гурван жил гаруйн хугацаа үлдээд байгаа. Гэвч, энэ оны нэгдүгээр сарын 20-нд библи судар дээр баруун бараан тавин Ерөнхийлөгчийн тангаргаа өргөсөн Доналд Трамп албан тушаалдаа томилогдсоноос хойш жил ч болоогүй байхад дараагийн сонгуулийнхаа кампанит ажилд зарцуулах мөнгөө цуглуулж эхэлжээ. Тэрбээр Цагаан ордноос холгүй байрлах өөрийн эзэмшлийн “Трампа Интернэйшнл” зочид буудлаа мөнгө хуримтлуулахад яг тохирох газар хэмээн сонгосон гэнэ. Улс төрд аль нэг албан тушаал хахсан туршлагагүй ч, өнгөрсөн сонгуульд Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтонийг ялж, Ерөнхийлөгч болсон үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп өнгөрөгч лхагва гарагт оройн зоог зохион байгуулж, тус үйл ажиллагаанд оролцсон хүмүүсээс 35-100 мянган ам.долларын хандив авчээ. Энэ үйл ажиллагаагаар цугларсан мөнгө нь Бүгд найрамдах нам болон Ерөнхийлөгч Доналд Трампын дараагийн сонгуульд зарцуулагдах аж.

АНУ-д Ерөнхийлөгч улс төрийн үйл ажиллагааны хүрээнд нам болон өөрийн төлөө мөнгө цуглуулах хандивын уулзалт, үдэшлэг зохиож ирсэн уламжлал байдаг гэнэ. Гэтэл үл хөдлөх хөрөнгийн тэрбумтнаас Ерөнхийлөгч болсон Д.Трампын тухайд өөрийн эзэмшлийн зочид буудалдаа уулзалт зохион байгуулан хандив авсан нь ирээдүйд болох сонгуулийн кампанит төдийгүй өөрийн бизнестээ орлого оруулсан явдал болж буйг эх сурвалжууд онцолж байна.



Пак Гын Хед цаазын ял онооно хэмээн сүрдүүлэв

БНСУ-ын Ерөнхийлөгч асан Пак Гын Хе Хойд Солонгосын удирдагч Ким Жон Уны амийг хөнөөхөөр төлөвлөж байсан нь ил болсон. Тэгвэл үүнтэй холбоотойгоор Пхеньян Пацыг цаазын ялаар шийтгэнэ хэмээн заналхийлжээ.

БНАСАУ-ын төрийн өмчит KCNA агентлагаар тус улсын тэргүүний мэдэгдэл цацагдсан бөгөөд энэ үед Ким Жон Уны амийг бүрэлгэхээр төлөвлөж байсан тухай хэргийг сөхөж, “Бид гадаад дотоодын аль нь ч бай, дайсан Пак Гын Хед цаазын ял ногдуулахаа мэдэгдэж байна” гэжээ. Авлига, төрийн үндэсний ассамблейд итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хурааж, огцруулсан экс Ерөнхийлөгч Пак Гын Хе одоогоор БНСУ-ын Сөүл хотын

цагдан хорих төвд хоригдож байгаа билээ.

Түүнчлэн, Пхеньян энэ сарын 28-ны мэдэгдэлдээ БНСУ-ын Засгийн газарт хандан “олон улсын терроризмын гэмт хэрэгтэн болох Пак Гын Хе нэн даруй шилжүүлж өгөх”-ийг шаардсан байна. БНСУ-ын ээлжит бус Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан Мүн Жэ Ин эдүгээ АНУ-д айлчлал буй. Хоёр улсын төрийн тэргүүний хэлэлцэх гол сэдэв нь Хойд Солонгос улсын эсрэг авах арга хэмжээ аж. Тэр үүднээс Пхеньяны зүгээстэдний уулзалтыг эсэргүүцэн өмнө нь АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын улс төрийн бодлого нацист Германы дарангуйлагч Адольф Гитлертэй төстэй хэмээн шүүмжилсэн мэдэгдэл хийж байсан удаатай.

ЭХЛЭЛ **УЛС**

Нийтлэл · Яри

НИЙГЭМ
МАРГААШН
ЭХЭЛНЭ
2 цвгийн өмнө

ШАР МЭДЭЭ

ММINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAX
PLAY STORE

TATAX
APP STORE

АПП TATAX

БҮХ СЭДЭВ ▾

Шилдэг · Архив

Хугацаа 2017

exoo

50%

50%

НИЙГЭМ
МАРГААШНААС БҮСЭЭ ЧАНГАЛАХ САР
ЭХЭЛНЭ
2 цвгийн өмнө

© 3 цагийн өмнө

АСЕМ-ын “Ази-Европын Хүнсний аюулгүй байдал”-ын

САНАЛ БОЛГОХ

ОРОН НУТАГ

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ

Дархан-Уул аймгийн Ерөнхий архитектор Д.Элдэвсайхантай ярилцлаа.

-Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний талаар яриагаа эхэлье?

-БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 196/260-р тогтоолоор Дархан хотыг байгуулах тогтоол батлагдаж 1961 оны 10 дугаар сарын 17-нд анхны шав тавигдсанаар Дархан хот байгуулагдсан. Дархан хотыг барьж байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажлууд 1960 оноос эхэлж хотын анхны ерөнхий төлөвлөгөөг 1963 онд ЗХУ-н ГОРСТРОЙПРОЕКТ институт бүхий 13-н институтэд боловсруулж барилга байгууламжийн ажил эхэлсэн байдаг. Хоёр дахь ерөнхий төлөвлөгөөг 1983 онд ЗХУ-ын Москва хотын "ЦНИИП Градостроительство" институтэд боловсруулан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар баталж,

шалгарсан. Одоо шинээр баригдаж байгаа болон баригдах гэж байгаа барилгуудад зураг төсөл боловсруулах шатанд архитектур төлөвлөлтийн даалгаврыг чанд мөрдүүлэх тал дээр тодорхой ажлуудыг зохион байгуулж байна. Ингэснээр тухайн газар дээр газар эзэмшигчийн хүслээр биш хотын шаардлагад нийцсэн төлөвлөлтийн дагуу барилга баригдах нөхцөл нь бүрдсэн гэж ойлгож болно. Дархан хот анх байгуулагдсан цагаасаа хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөж ирсэн цаашдаа ч мөрдөж ажиллах болно гэдэгт итгэлтэй байна. Дархан хотын хот байгуулалтын бодлого болон түүний хэрэгжилт нь нийслэл Улаанбаатар болон бусад аймгуудыг бодвол маш цэгцтэй явж байгаа гэж миний хувьд дүгнэдэг.

-Сая та найман хороололд төлөвлөлт хийсэн гэж ярилаа. Дархан дэд бүтцийн хувьд хэр нөөцтэй хот вэ. Эдгээр



Д.ЭЛДЭВСАЙХАН: ДАРХАН АНХ БАЙГУУЛАГДСАН ЦАГААСАА ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ЧАНД МӨРДӨЖ ИРСЭН

төлөвлөлтийн хугацааг 2000 он хүртэл, хүн амыг 100000-д хүрэхээр тооцоолсны зэрэгцээ аж үйлдвэрийн төв зангилаа хот байхаар төлөвлөсөн. Дархан хотын архитектур орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал нь 1983, 2004 онд батлагдсан ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож байна. Монгол Улсын шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Дархан хотыг дэлхийн жишигт нийцсэн Монгол Улсын анхны жишиг хот болгон хөгжүүлэх" заалт тусгагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Дархан хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон 2050 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын төслийг боловсруулах ажлыг "Арт контракт" ХХК боловсруулж байна.

-Дархан хот ер нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу хөгжиж чадаж байна уу. Дархан хотын хот байгуулалтын өнөөгийн байдал ямар төвшинд байна вэ?

-2012-2016 онд Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу найман байршилд 197 га талбайд 10500 айлын аминь болон нийтийн орон сууцны хороолол төлөвлөж 2015 онд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан ажиллаж байна. Шинэ хороолол хотхон барьж байгуулахад эхний ээлжид дэд бүтцийг заавал шийдвэрлэх шаардлагатай байдаг. Энэ ажлын хүрээнд тус байршилдаа дулаан болон цахилгаан хангамжийн асуудлыг улсын төсвийн 20 орчим тэрбум төгрөгөөр шийдвэрлэсэн. Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар эдгээр төлөвлөгдсөн хорооллын гол зам болох 2.4 км замыг сахиан ашиглалтад орууллаа. Урьд өмнө нь хотын төвд олгогдсон 360 орчим нэгж талбарыг хотын төвийн хэсгийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд шинэ төлөвлөлтийн дагуу байршуулсан. Манай аймаг 2015 онд хот байгуулалтын чиглэлээр боловсруулсан бодлого болон түүний хэрэгжилтээр улсдаа тэргүүлсэн сайхан амжилт гаргасан. Мөн 2016 онд III байранд, 2017 онд улсдаа нийслэлийн дараа хоёрдугаарт аймгуудын хэмжээнд I байранд

хорооллыг дэд бүтцээр хангах боломж бий юу?

-Мэдээж төлөвлөлтийг гүйцэтгэх шатанд чиглэл чиглэлийн мэргэжлийн байгууллагууд бүгд оролцсон. Дархан хот нь одоогоор дулааны эрчим хүчнийхээ 64, цэвэр усан хангамжийн 30, цэвэрлэх байгууламжийн 60 хувийг ашиглаж байна гэсэн тооцоолол бий. Мөн манай аймагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бохир усны менежментийг сайжруулах төсөл хэрэгжиж байгаа. Дулааны цахилгаан станцын 35 МегаВаттын өргөтгөлийн санхүүжилт шийдэгддэг. 2016 онд 10 МегаВатт-н хүчин чадалтай нарны цахилгаан станц ашиглалтад орлоо. Дархан сумын Хөтөл хороололд гадны хөрөнгө оруулалтаар ахуйн хог хаягдлыг шатааж эрчим хүч үйлдвэрлэх төсөл хэрэгжихээр ТЭЗҮ-ээ боловсруулж байна гэх мэтчилэн дэд бүтцийн хувьд хангалттай нөөцтэй гэж ойлгож болно.

-Төлөвлөгдсөн хорооллуудаас барилгажиж байгаа хороолол байгаа юу?

-Дархан сумын 9,10 дугаар багт орших эдэлбэр газартай амины орон сууцны 25 дугаар хорооллын хашаажуулалт болон ИШС-ний угсралтын ажлыг 2016 онд Бурхант Хасаат ХХК бүрэн гүйцэтгэж дуусгалаа. Одоо хорооллын гол замын угсралтын ажлыг Дархан АЗЗА ТӨААТҮГ гүйцэтгэж байна. Эхний ээлжийн айлууд нь барилга угсралтын ажлаа дуусгаад ашиглалтад оруулах шатанд явж байна. Энэ төсөл маань Дархан хотдоо төдийгүй улсын хэмжээнд хэрэгжиж байгаа томоохон төсөл юм. ИШС болон хашаажуулалтын санхүүжилтийг газар эзэмшигчид нь өөрсдөө санхүүжүүлснээрээ онцлогтой төсөл болсон.

-Дархан хотод гэр хорооллын дахин төлөвлөлт хийх боломжтой юу. Боломжтой бол ямар арга замаар хэрэгжүүлэх вэ?

-Мэдээж боломжтой. Монгол Улсад гэр хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах үйл явц Улаанбаатар хотод 2012 оноос хойш хэрэгжиж байгаа. Мөн хууль эрхзүйн орчинг сайжруулах зорилгоор 2015 онд "Хот Суурин Газрыг

Дахин Хөгжүүлэх Тухай Хууль" батлагдсан. Гэр хорооллыг дахин төлөвлөж барилгажуулах ажлын гүйцэтгэгч нь заавал хуулийн этгээд байх ёстой гэсэн заалттай. Манай хотын хувьд дахин төлөвлөлтийн ажлыг хийх нөхцөл шаардлага нь Улаанбаатарыг бодвол харьцангуй бага. Тийм учраас барилгын компаниуд манай аймагт дахин төлөвлөлтийн ажлыг хийж гүйцэтгэх сонирхол одоогоор бага байдаг байх. Гэр хорооллын иргэд дахин төлөвлөлт хийлгэх сонирхол маш их байдаг. Дахин төлөвлөлт хийх үед иргэдээс газрыг нь худалдаж авах эсвэл газрынх нь оронд байр өгөх маягаар шийддэг. Хэрэв иргэн, аж ахуйн нэгж хүсэлт гаргавал дахин төлөвлөлт хийх боломж нь бүрэн нээлттэй.

-Хот төлөвлөлт, газар олголт, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэхтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагууд маань хэрхэн уялдаатай ажиллаж байна вэ?

-Монгол Улсын Засгийн газрын 68 дугаар тогтоолын дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон, барилгын ажлыг байнгын ашиглалтад авах комисс ажиллуулахдаа тухайн барилгын улаан шугамын зөрчлийг хянаж зөрчлийг арилгуулах, баригдах барилга байгууламжийг тухайн орон нутгийн онцлог, оршин суугчдын зан заншил, үндэсний архитектурын уламжлал, орон зайн зохиомж, орчны барилгажилттай нь уялдуулан батлагдсан зураг төслөөр барилуулах чиглэлийг онцгой анхаарч, орчны тохижилт, зам талбай, гэрлэн чимэглэл, архитектурын жижиг хэлбэрүүдийг иж бүрнээр гүйцэтгүүлэх тал дээр аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар болон бусад холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

-Цаашдын ажлын төлөвлөгөөнийхөө талаар товч мэдээлэл өгөхгүй юу?

-Дархан хотын одоо байгаа суурьшлын бүстэй хил залгаа 7, 14, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон амины орон сууцны 31 дүгээр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөл, Мангирт, Хабитатын чиглэлийн

ИШС-ний гол шугамын ажлын үргэлжлэл болох тараах шугамын ажлыг гүйцэтгүүлэх тал дээр аймгийн ЗДТГ, Захирагчийн алба болон ГХБХБГ-тай хамтран ажиллаж байна. Мөн Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын угсралт болон тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах бэлтгэл ажлыг дуусгахаар ажиллаж байна.



Дархан хотын анхны хэмжилт /1960 оны 4 дүгээр сар/



1968.07.26-нд Нийтийн тээвэрт ЛАЗ-695 маркын 2 автобус анх удаа гарлаа



Манхан толгойг сэтгэлж 2 урсгалтай автозам ашиглалтад орууллаа. /1967-1968/



1969 онд ЗХУ-ын тусламжаар байгуулагдсан "НАЙРАМДАЛ ХОРООЛОЛ"-ын Байгууламжийг ашиглалтад хүлээж авлаа



МЭДЭЭЛЭЛ

МУБИС-ийн ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

Улаанбаатар хотоос элсэгчдийг 2017 оны долдугаар сарын 01-ээс 2017 оны долдугаар сарын 03-ны өдөрүүдэд МУБИС-ийн элсэлтийн http://burtgel.surgalt.mn/ онлайнаар болон төв сургууль гээр бүртгэнэ.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬД 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монгол Улсын БСШУС-ын сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан журам болон энэхүү журмыг баримтлан, Монгол Улсын Боловсролын их сургууль оюутан элсүүлнэ.
1.2 МУБИС-ийн бакалаврын өдрийн ангид аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг "Аймаг, орон нутгаас Монголын их дээд сургуулиудын консорциум (МИДСК)-ын гишүүн их дээд сургууль, коллежид 2017 онд оюутан элсүүлэх журам"-ын дагуу МИДСК зохион байгуулна.

ХОЁР. БҮРТГЭХ

- 2.1 Улаанбаатар хотоос элсэгчдийг 2017 оны 07 дугаар сарын 01-ээс 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрүүдэд МУБИС-ийн элсэлтийн http://burtgel.surgalt.mn/ вебээр онлайн болон төв сургууль дээр бүртгэл хийгдэнэ.
2.2 Элсэлтийн бүртгэлийн хураамж 10000 төгрөг байх ба онлайнаар төлнө.
2.3 МУБИС-ийн бакалаврын өдрийн ангид оюутан элсэх хөтөлбөр, ерөнхий шалгалтын оноо, тооцох хичээлийн талаарх мэдээллийг хавсралт 1-ээс үзнэ үү.

ГУРАВ. ЭЛСҮҮЛЭХ

- 3.1 Боловсролын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагын зохион байгуулсан ерөнхий шалгалтын оноог үндэслэн оюутан элсүүлнэ. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн мэргэжлийн хавсралтад заасан хичээлээр 2015, 2016, 2017 онд ерөнхий шалгалт өгч, 400-аас доошгүй оноо авсан байна.
3.2 Аавьяас, үр чадвар шаардах багш-дизайн технологийн, багш-дүрслэх урлаг, багш-зураг зүй дизайны, компьютер-график дизайн, багш биений тамир, спортын дасгалжуулагч зэрэг хөтөлбөрөөр элсэх бол ерөнхий шалгалтаас гадна үр чадварын шалгалт өгнө.
3.3 Спортын өндөр үр чадвартай (спортын олон улсын тэмцээний шалгалттай болон гавьяат тамирчин) элсэгчийг Багш, биений тамирын боловсрол хөтөлбөрөөр үр чадвар 100% оноотой бол эцнээс ангид элсүүлэн суралцуулна.

- 1. Программ хангамж
2. Экологи
3. Аялал жуулчлал /түүх, аялал жуулчлал/
4. Хэл, уран зохиол
5. Спортын дасгалжуулагч
6. Аялал жуулчлал /спортын, аялал жуулчлал/
7. Хувцасны дизайн
8. Боловсрол судлал
9. Нийгмийн ажил
10. Сэтгэл судлал
11. График дизайн
12. Сэтгүүл зүй

- 3.20 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан ЭМД-ын тухайн хуулийн дагуу 18-н нас хүрсэн тохиолдолд оюутан ЭМД-ын жилийн төлбөр болох 28800 төгрөг төлсөн элсэгчийг бүртгэнэ.
3.21 "Багш, математик, байгалийн ухаан" болон "Багш, урлагийн боловсрол хөтөлбөр"-өөр 600-аас дээш оноотой, "Багш, бага ангийн болон сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр"-өөр 550-аас дээш оноотой эрэгтэй элсэгчийг эхний жилд МУБИС-ийн оюутныг дэмжих сангаас сургалтын төлбөрийн 50% тэтгэлэг олгоно.
3.22 Элсэлтийн ерөнхий шалгалтын босго онооны шалгуурыг хангасан бөгөөд TOFEL, IBT 50, SAT 1500, Хятад хэлний HSK 4.0, Солонгос хэлний TOPIK 3, KLPT 3, Орос хэлний ТРКИ А1, Япон хэлний N 3-аас дээш оноотой элсэгчийг шууд элсүүлнэ.

ДӨРӨВ. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 4.1 МУБИС-д суралцах эрхийн бичиг авч, сургалтын төлбөрөө бүрэн төлсөн элсэгчийг 2017 оны 08 дугаар сарын 16-аас 21-ны өдрүүдэд бүрэлдэхүүний сургуулиуд дээр бүртгэнэ. 2017 оны 08 дугаар сарын 21-ээс 25-ны хооронд /"0" хоногт/ хичээл сонголт хийгдэнэ. 2017 оны 08 дугаар сарын 28-д 1-р долоо хоног эхэлнэ.
4.2 Архангай аймаг дахь Багшийн сургуульд элсэн суралцах эрхийн бичиг авч, сургалтын төлбөрөө Багшийн сургууль дээр бүртгэнэ. Хичээл 08 дугаар сарын 28-нд эхэлнэ.
4.3 Элсэгч нь дараах материалыг бүрдүүлж, өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:
- Бүрэн дунд буюу түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг /эх хувь/
- Ерөнхий шалгалтын онооны батламж
- Суралцах эрхийн бичиг
- Хувийн хэрэг
- Иргэний үнэмлэх
- 3x4 хэмжээтэй чээж зураг хоёр хувь

Элсэлтэй холбоотой мэдээлэл авах вэб сайт: http://www.mnue.mn, http://burtgel.surgalt.mn/

Харилцах утас: 976-311-764

Элсэлтийн төв комисс: 326179, 323102

МУБИС-ийн Элсэлтийн төв комисс

МУБИС-ийн бакалаврын өдрийн ангид оюутан элсүүлэх хөтөлбөр, ерөнхий шалгалтын оноо, тооцох хичээл

Table with 4 columns: No, Бакалаврын багц хөтөлбөр, Хөтөлбөрийн нэрчилгээний чиглэл /сонгон мэргэжил/, Ерөнхий шалгалтын оноо тооцох хичээл. Rows include subjects like English, Mathematics, Physics, Chemistry, Biology, Design, etc.

* - үр чадварын шалгалт өгнө
** - хэвлүүлсэн зөвхөн бүтээл, нийтлэл зэрэг уран бүтээл, мөн аймаг, улсын хэмжээний "Хурал тулга" болон түүнтэй дүйцэх уралдаанд оролцсоныг зарчмын баримт, өргөмжлөл, үнэмлэх зэрэг үндэслэн шалгаруулж элсүүлнэ.
*** - Архангай багийн сургуульд "Багш, бага ангийн боловсрол" хөтөлбөрөөр бүртгүүлэгч нь Монгол хэл эзэлж Математикийн суурь шалгалтын аль нэгийг өгч 400 болон түүнээс дээш оноо авсан байна.

МУБИС-ийн хуваарт сонголт

Онооны жагсаалтыг 2017 оны 07 сарын 03-ны өгөр 22:00 цагаас http://burtgel.surgalt.mn/ http://msue.edu.mn/ сайтаас харна. Хуваарь сонголт 2017 оны 07 сарын 04-05-ны өдөрүүдэд явагдана.

Лавлах утас: 976-11-311764

СПОРТ



Жудогийн домог Нэйл Адриэн Адамс Монголд ирнэ

Их Британийн жүдо бөхийн амьд домог олимпын наадмын хошой мөнгөн медальт, дэлхийн аварга Нэйл Адриэн Адамс Монголын жүдогийн багш нарт номын дуу сонгохоор манай оронд ирнэ. Олон улсын жүдо бөхийн холбооны эксперт багшаар ажиллаж байгаа Нэйл Адамс Монголын багш, дасгалжуулагчдад долдугаар сарын 4-5-нд Спортын төв оронд сургалт зохион байгуулна. Нэйл Адамс нь "Москва-1980", "Лос-Анжелес-1984" олимпын наадмын мөнгө, ДАШТ-ий нэг алт, нэг мөнгө, хоёр хүрэл медальт, Европын таван удаагийн аварга болж байсан алдартай жүдоч билээ. Жудогийн танхимд болох уг нээлттэй сургалтад жүдо бөхийн хөдөө орон нутгийн багш дасгалжуулагч, шүүгч нарыг өргөнөөр хамрагдахыг МЖБХ-ноос урьж байгаа юм. Нэйл Адамс 2017 оноос жүдо бөхөд хэрэгжиж байгаа дүрмийн өөрчлөлтийг боловруулсан Олон улсын жүдо бөхийн холбооны эксперт багшаар ажиллаж байгаа юм.

АМЖИЛТЫН ЭЗЭН

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

-Харүбашёгийн дараа нутаг буцаж, өвдөгөө эмчлүүлсэн гэсэн үү?

-Харүбашёгийн дараа хоёр долоо хоног орчим хугацаагаар Монголдоо очиж эмчилгээ хийлгээд ирсэн. Тэгсний ачаар биеийн байдал дээрдэж байна. Хоолны дэглэм барьж, хөнгөн дасгал хийж байгаа. Одоогоор 11 кг орчим жин хаясан. Харүбашёгийн дараа алхаж ч чадахгүй байсан учраас өвдгөндөө хэт ачаалал авахгүйн тулд жин хасах зорилго тавьсан байгаа.

-Өмнөх башёгийн 14 дэх өдрийн барилдаанд Готошёогикүтэй барилдаж давсан. Тэр үед үзэгчид янз бүрийн үгээр доромжлон хашгирч байлаа. Гэтэл та башёгийн сүүлийн өдөр хоёр дараалж унасан байдаг. Тухайн үед гэмтлийн талаар нэг ч удаа дурсаагүй шүү дээ?

-Би одоо юу ч ярьсан бай шалтгаг төдий болох учраас тэр талаар ярьмааргүй байна. Өөрөө л муу барилдсан учраас тэр талаар ярих шаардлагагүй байх. Одоо ярих зүйл гэвэл өмнөхөөсөө сургамж авч, цаашид илүү хичээх юм. 2015 оны зуны башёд сэкивакэ цолтойгоор анх удаагаа түрүүлж, ёкозүна болсон. Түүнээс хойш дээд зиндаанд барилдаж



Тэрүнофүжи:

Өөрийн хэр хон явахыг хартаар байна

байгаад 2016 оны нацүбашёд хоёр удаа даваад 13 дараалж унасан. Тэр үед яаж ч хичээгээд сайн барилдаж чадаагүй юм. Тиймээс энэ удаа янз бүрээр хэлүүлсэн ч гэсэн аль болох олон унахгүйг л хичээсэн.

-Башёгийн сүүлийн өдөр дэвжээнд байхад чинь "Монгол руугаа зайл" гэж ээргээр үзэгчид хашгирч байсан. Та түүнийг сонссон уу?

-Башё дууссаны дараа хэвлэл мэдээллээс л сонссон. Тэр талаар заавал ярих хэрэггүй гэж үү. /хэсэг чимээгүй болов/. Ний нуугүй хэлэхэд, сонссон.

-Дэвжээнд барилдах танд амаргүй байсан байх. Үүнээс гадна, бие махбодно ч бүрэн бэлтгэж чадаагүй байсан уу?

-13 дахь өдрийн барилдаанд /какарютай/ хуучин гэмтлээ сэдэрэсэн нь миний хариуцлагагүйнх. Ийм зүйлийг хүмүүсийн өмнө ярих шаардлагагүй гэж бодсон. Тэгээд л одооноос бие махбодыдоо анхаарч байгаа хэрэг.

-Тийм байх нь ээ. Таны энэ

...Ичиножёо, Эндо хоёрын сүүдэрт сайн нуугдсан нь ч болсон юм уу /инээв/. Ямар ч гэсэн тэр башё дараа "Озэки болно" гэсэн зорилго тавьж байсан ч, дэвшсэн зиндаандаа Гойэдод ялагдсан нь хамгийн харамсалтай барилдаан байсан. Одоо ч мартагддаггүй юм...

шндвэрт яг юу нөлөөлсөн юм бэ?

-Озэки болсноос хойшхи хоёр дахь башёд /2015 оны намар/ Кисэносатотай барилдах үедээ баруун холнийхөө өвдгөө гэмтээсэн. Тэр л нөлөөлсөн хэрэг. Бэртэл авах хуртлээ "яаж ч барилдсан ялах" юм шиг сэтгэж явлаа. Бие бялдар, дасгал сургуулилтаа эрдэж, зоригтой барилддаг байсан юм.

Харин тэр барилдааны дараа "за болохгүй болж байгаа юм байна шүү" гэсэн анхны мессежээ авсан. Гэмтэл, бас өөрийн сүмо дахь үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй бол болохгүй нь гэж бодсон хэрэг.

-Цол нэмэх үедээ, нэрээ "Тэрүнофүжи" болгож өөрчилсөн байх аа?

-Шёовагийн ёкозүна "Тэрүкүни" болон багшийн

"Асафүжи"-гийн нийлбэр. Үүний ачаар л дараа жилийнх нь харүбашёд сүмо бөхийн хамгийн дээд зиндаанд орж барилдаж чадсан гэж боддог шүү. Тэр жил анхныхаа башёд /нэгдүгээр сар/ анхны барилдаанаа ахлах сургуульд манай доод анги байсан Ичиноёотай хийж билээ. Ичиножёо нацүбашёд /тавдугаар сар/ сайн барилдаж, намрын башёд /есдүгээр сар/ зиндаа өгсөн гарч ирсэн. Дараа нь Эндо. Ичиножёогоос нэг башёгийн сүүлд гарч ирээд л ижил зиндаанд барилдаж эхэлсэн. Сүмо бөхтэй холбоотой бүхий л мэдээлэл зөвхөн тэдний тухай байв уу гэмээр л гайхалтай байсан.

-Танд гомдолтой байсан уу?

-Тийм зүйл огтхон ч бодоогүй. Хөөрхөн дүү минь юм чинь /инээв/. Гэхдээ Ичиножёо /1993/, Эндо /1990/ нарыг сүмогийн дэвжээнд хүч түрж гарч ирснээс хойш тэднийг хүчтэй сүмочид гэж харах болсон. Дараа нь Такаясү бас гарч ирсэн. 1991 онд төрсөн Такаясү жьюрёо зиндаанд гарч ирснээс хойш бид хамтдаа

-Дэвжээний багш, хамт сурацдаг нөхөд минь бэлтгэл сургуулилт сайн хийлгэснийг байх аа. Ичиножёо, Эндо хоёрын сүүдэрт сайн нуугдсан нь ч болсон юм уу /инээв/. Ямар ч гэсэн тэр башё дараа "Озэки болно" гэсэн зорилго тавьж байсан ч, дэвшсэн зиндаандаа Гойэдод ялагдсан нь хамгийн харамсалтай барилдаан байсан. Одоо ч мартагддаггүй юм.

-Энэ зуны башёд таныг ямар барилдаан үзүүлэхийг үзэгчид хүлээж байгаа байх?

-Гэмтлээс хойш тогтмол амжилт гаргаж чадахгүй байгаа. Юун түрүүнд амжилт гаргахыг л хүсч байна. Саяхан сүмо барилдсан чинь үнэхээр хөгжилтэй байсан шүү. Өмнө нь ингэж ер бодож байсангүй. Магадгүй ойд барилдаагүй учраас тэр байх. Намайг озэки болоход хэвлэл мэдээллийнхэн гээд маш олон хүмүүс дэмжиж байсан. Гэмтэл авсны дараа эргэн тойрны хүмүүс... Намайг энэ үед ч гэсэн дэмжиж байсан хүмүүсээ би хэзээ ч мартахгүй, үргэлж санаж явах болно. Тэдгээр хүмүүсийнхээ төлөө илүү сайн хичээж барилдах болно. Өөрийгөө хэр холь явахыг харахыг хүсч байна.

Манай хөнгөн атлетикчид ААШТ-д оролцохоор болжээ

Ирэх долдугаар сарын 5-9-нд Энэтхэг улсад болох хөнгөн атлетикийн насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд манай улсын зургаан тамирчин хурд, хүчээ сорино.

Тэмцээнд оролцох баг тамирчдаа дасгалжуулагч А.Амарбаясгалан ахалж тивийн АШТ-ий дөрвөн зайд хурдаа сорих юм. Тухайлбал, 4x100 метрт Б.Ачитбилэг, 100, 200, 4x100 метрт Д.Шинэбаяр, Г.Шижирбаатар, 400, 4x100 метрт А.Жанцандорж, 5000, 10000 метрт Д.Гантулга, Б.Мөнхзаяа нар оролцоно. Энэ удаагийн Ази тивийн АШТ-ий үеэр олон улсын хөнгөн атлетикийн холбооны дөрвөн хурал болох юм.



Хүчингүйд тооцов

5797195 регистрийн дугаартай Эко Эрдэнэс Бьюлдинг ХХК-н эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт хийх гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.
Далай овогтой Бөхбаатар Төв аймгийн Сэргэлэн сум зөрлөг дэнгийн ам гэрчилгээний дугаар 186669284229671, улсын бүртгэл 0004502220 тоот бүртгэлтэй Зга талбайтай үйлдвэр, үйлчилгээний зориулалттай эзэмшлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд болгов.
Оюунгэрал овогтой Бумэрдэнэ ЖЯ850308 мэргэшсэн жолооны үнэмлэх гээгдүүлсэн тул хүчингүйд болгов.
"Сүмбэр Ойл" ХХК-ийн 5322154 регистрийн дугаартай аж ахуйн гэрчилгээг хүчингүйд болгов.
Цэнд овогтой Цээсүрэнгийн улсын бүртгэлийн ү-2205012633 дугаартай 0050297 тоот орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ гэсэн тул хүчингүйд тооцов.

СПОРТ

ЖУДО

Н.БОЛД

Олон улсын жудо бөхийн холбооны календарчилсан төлөвлөгөөнд багтсан Хөххотын Гран при тэмцээн өнөөдөр эхлэх билээ. Өвөр Монголын нийслэлд анх удаагаа болох гэж буй энэхүү тэмцээнд дэлхийн 26 орны эрэгтэй 132, эмэгтэй 120, нийт 252 жүдоч өрсөлдөхөөр мэдүүлгээ өгөөд байна. Мэдээж Өвөр Монголд болж байгаа гэдэг утгаараа Хятадын багаас эрэгтэй, эмэгтэй 28, 28 жүдоч барилдах юм. Тэгвэл Монголын шигшээ эрэгтэй 13, эмэгтэй 12 жүдоч оролцохоор мэдүүлгээ өгчээ. Мөн Оросууд 24 тамирчнаа оролцуулж байгаа юм байна. Манай эрэгтэй багийн хувьд 60 кг-д Д.Амаргүвшин, Г.Болдбаатар



Г.Орлов / АНУ / УЖЖН

Хөххотын ГРАН-ПРИД манай 25 жүдоч өрсөлдөнө

нар барилдах бол 66-д Д.Алтансүх, Ё.Басхүү хоёр зодоглохоор болжээ. Харин 73 кг-д С.Баяргүвшин, Ц.Цогтбаатар нар барилдана. Ц.Цогтбаатарын хувьд Рио-2016-гаас хойш бараг л тэмцээнд оролцоогүй байсан. Тэгвэл ийнхүү Хөххотын Гран прид зодоглож, тэр дундаа 73 кг-д өрсөлдөхөөр болоод байна. Цаашид ч тэрбээр 73 кг-д хүч үзнэ

гэдгийг холбооны зүгээс хэлж буй. Эрэгтэйчүүдийн 81 кг-д Б.Гаажадамба, Н.Дагвасүрэн нар барилдах бол 90 кг-д Г.Алтанбагана, Э.Мөнхжаргал хоёр өрсөлдөх ажээ. -100 кг-д Б.Жанчивдорж барилдахаар болоод байна. Уг нь Л.Отгонбаатар -100 кг-д барилдахаар мэдүүлэгт багтаад байсан. Харин +100 кг-д Б.Тэмүүлэн, Ө.Дүүрэнбаяр нар барилдана. Эмэгтэйчүүдийн хувьд 12

жүдоч Хөххотод өрсөлдөнө. 48 кг-д Б.Хорлоо, Э.Гэрэлмаа гэсэн залуу бөхчүүд зодоглохоор болж. Тэгвэл 52-т Ч.Азаяа, А.Цолмон нар барилдах юм. 57-д Л.Энхрийлэн болон Олимпын мөнгөн медальт Д.Сумъяа нар барилдахаар мэдүүлэгт багтжээ. 63-т Ц.Цэрэннадмид, Б.Ганхайч нар зодоглох бол 70 кг-д Б.Хулан, М.Даваасүрэн гэсэн залуу тамирчид өрсөлдөх нь. -78-д бөх

барилдахгүй бол +78 кг-д Э.Гандиймаа болон Б.Мөнхтуяа нар Хөххотын гран прид өрсөлдөх нь ээ. Өвөр Монголд Азийн жудо хөгжсөн орнуудаас Япон, Солонгос жин тус бүрт шилдэг тамирчнаа илгээж байгаа юм байна. Японы хувьд эрэгтэй, эмэгтэй тус бүр долоон тамирчны мэдүүлэг өгч. Тэгвэл Солонгос эрэгтэй долоо, эмэгтэй 11 жүдочоо өрсөлдүүлэх нь.

Улаанбаатарт:

Маргааш
 Өдөр 34
 Шөнө 18

Нөгөөдөр
 Өдөр 29
 Шөнө 19

Өдрийн зурхай

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР

Наран ургах шингэх: 04.56-20.54
 Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие энхрийлүүштэй. Гэрийн үйл, бие угаах, хуцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол туу. Нохой уливал атгалан сайн болох, тагнай загатнавал дээрэл ирэх, бие татвал аюул болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

FOOTBALL NEWS

Чили финалд үлдэж, ПОРТУГАЛ МУЛТАРЛАА



аварга Чилийн шигшээ хоорондоо тулсан. Тэгвэл хоёр баг үндсэн цагт хуурай тэнцэж, торгуулийн цохилтоор асуудлаа шийджээ. Сүүлийн үед хүчирхэг бүрэлдэхүүнтэй болоод байгаа Португалын цохилт цохиход маш муу байж, 3:0-аар хожигдлоо. Португалаас эхний гурван цохилтыг Нани тэргүүтэй тамирчид цохьсон ч Браво бүгдийг нь хааж чадсан юм. Ийнхүү Чили финалд шалгарч үлдэж чадлаа. Өнгөрсөн шөнө дэлхийн аварга Германы шигшээ баг Мексиктэй тулсан юм. Аль хожсон нь Чилитэй цом булаалдах юм.

Хамесын төлөө "Реал"-д 80 сая евро санал болголоо



Английн алдарт "Манчестер Юнайтед" клуб "Реал Мадрид"-ын хагас хамгаалагч Хамес Родригесыг худалдаж авахыг хүсч байгаа. Тэгвэл "Улаан чөтгөрүүд" түүний төлөө 80 сая евро санал болгосон талаар "Football Italia" портал сайт бичжээ. Ер нь бол Хамес Эзэн хааны багийн сэлгээнд сууж, банз халааж байгаадаа сэтгэл дундуур байгаа юм. Мөн тэрбээр өнгөрсөн улиралд 22 тоглолтод оролцсоны 13-т нь гарааны бүрэлдэхүүн гарчээ. Тэгэхдээ найман гоол оруулж, зургаан оновчтой дамжуулалт өгсөн юм байна.

Бидэнд тохиолдсон

Хүндхэн хөгтэй явдлууд

Пеле: Неймар Бразилын шилгээг хөлбөмбөгч, харин дэлхийнх биш

Бразилын алдарт хөлбөмбөгч Пеле ОХУ-д болж буй Холбоодын цомын тэмцээний хүндэт зочноор уригдсан билээ. Тэгвэл түүнээс "Спорт-Экспресс"-ийн сурвалжлагч ярилцлага авч, олон сэдвийг хөндөн ярилцжээ. Тэр дундаа сүүлийн жилүүдэд Бразил тоглогч дэлхийн шилдэг болж чадахгүй байгаа талаар ч ярьсан байна. Пеле энэ асуултад "Одоохондоо "Алтан бөмбөг" авчир хэмжээний Бразил тоглогч харагдахгүй байна. Неймарт ийм хэмжээний авьяас чадвар хангалттай байгаа ч нутагтаа болсон ДАШТ-д тааруу тоглосон. Тэр одоохондоо Бразилийн хамгийн шилдэг хөлбөмбөгч ч дэлхийнх биш" хэмээн ярьжээ.



"Монако" Лемарыг "Арсенал"-д зарахаас татгалзлаа

Английн "Арсенал" клуб "Монако"-гийн хагас хамгаалагч Тома Лемарыг авахаар оролдож байгаа билээ. "The Guardian"-ы мэдээлж байгаагаар Монако хотын баг Лемарын төлөө "Арсенал"-ын тавьсан 35 сая еврогийн саналаас татгалзжээ. Учир нь тэд Лемарыг энэ зун зарахгүй, багийн бүрэлдэхүүнд хадгалж үлдэхийн төлөө чадах бүхнээ хийж буй аж.

УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цуа, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танаг:


- Ган болон мөнгөн зүү, шалнагаан зүү
- Хануур, сам соруул
- Шарлага
- Бумба төвшнө засал
- Халуун чулуу, лавсан халуун жин засал
- Эмчилгээний цэгэн бариа
- Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
 Холбогдох утас: 9999-5584
 9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/